



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 04 өдөр

Дугаар №102

Чойр

Өвөлжилт хүндэрсэн сумдад малын
тэжээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Улсын нөөцөөс бараа материал гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай” 449 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Онцгой байдлын газрын Улсын нөөцийн 140 дүгээр салбараас малын тэжээлийн үнийг 50 хувь хямдруулан, өвөлжилт хүндэрсэн сумдын малчдад борлуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг 1 дүгээр, сумдад олгох малын тэжээлийн хэмжээ, хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хуваарилагдсан малын тэжээлийг тараах, заавар журмыг мөрдөж ажиллах, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин үр дүнг тайлагнаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Х.Сүхбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн А/62 дугаар захирамжийн 1. дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Н.Бямбасүрэн (Онцгой байдлын газрын 140 дүгээр салбарын дарга, ахлах дэслэгч)
Гишүүд:	Т.Бат-Эрдэнэ (Сүмбэр сумын Засаг дарга) Б.Ганбаяр (Баянтал сумын Засаг дарга) Ч.Сугармаа (Шивээговь сумын Засаг дарга) Ц.Баярхүү (Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа) Б.Баярсайхан (Тагнуулын хэлтсийн дарга, хурандаа) Э.Түвшинзаяа (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Нарийн бигийн дарга:	Ц.Цэрэндаваа (Улсын нөөцийн 140 дүгээр салбарын нөөцийн барааны нярав, дэд ахлагч)

Аймгийн Засаг даргын 2024 оны 0.1
дүгээр сарын 04-ны өдрийн 4/02 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



Малын тэжээлийн хуваарь

№	Сумдын нэр	Хэмжих нэгж	Олгох хэмжээ
1	Сүмбэр сум	Тонн	20тн
2	Баянтал сум	Тонн	2,5тн
3	Шивээговь сум	Тонн	5,8тн

Сумдын малчин болон мал бүхий иргэдийн судалгаа

№	Сумдын нэр	Малчин өрх	Мал бүхий	Нийт
1	Сүмбэр сум	598	250	848
2	Баянтал сум	88	72	160
3	Шивээговь сум	114	66	180
4	Бүгд	800	388	1188